Сумьяабазар, Компани болон НАТАЛЯ-1 нь 2010 оны 7-р сарын 29-ны өдөр Ерөнхий нөхцлүүдийн гэрээ (цаашид “Ерөнхий нөхцлүүдийн гэрээ” гэх) байгуулсныг;

Компани нь Монгол Улсын Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын газраас олгосон ашигт малтмалын хайгуулын 8573Х тоот тусгай зөвшөөрөл (цаашид “Лиценз” гэх)-ийн бүртгэгдсэн эзэмшигч мөн болохыг;

Компани нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагуудад Гадаадын хөрөнгө оруулалтын тухайн Монгол улсын хууль болон Компанийн тухайн Монгол улсын хуульд заасан шаардлагыг хангах үүднээс энэхүү Гэрээг байгуулах үед дүрмийн сангаа нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 13,500 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх 135,000,000 төгрөг буюу 100,000 ам.доллар болгож нэмэгдүүлэх хүсэлтэй байгааг;

Талууд нь дээрх хөрөнгө оруулалтыг Компанийн дүрмийн санд нэмж оруулахыг зөвшөөрснийг;



НАТАЛЯ-1 нь энэхүү Гэрээний нөхцөл, болзлуудын дагуу Хувьцааны тавин нэгэн хувь (51%)-тай тэнцэх зургаан мянга найман зуун наян таван (6,885) ширхэг хувьцаа (цаашид “Захиалсан хувьцаа” гэх)-г Хувьцаанаас захиалахаа зөвшөөрснийг;

ТУС ТУС ТЭМДЭГЛЭН, Талууд нь дор дурдсаныг харилцан тохиролцов. Үүнд:

1-Р ЗҮЙЛ НЭР ТОМЬЁО

1.1. Энэхүү Гэрээнд өөрөөр заагаагүй бол том үсгээр бичигдсэн нэр томъёонууд нь Ерөнхий нөхцлүүдийн гэрээнд заасан утгатай ижил байна:

“**Ажлын өдөр**” гэдэгт (Бямба, Ням гариг болон бүх нийтийн амралтын өдрүүдээс бусад) Монгол улсад банкууд ажиллах өдрүүд (Даваа гаригаас Баасан гариг хүртэлх)-ийг ойлгоно;

“**Гэрээг хаах**” гэдэгт НАТАЛЯ-1 нь Хувьцааны 51%-ийн эзэмшигчээр бүртгэгдэх хэлцэл дуусахыг ойлгоно;

“**Гэрээг хаах өдөр**” гэдэгт энэхүү Гэрээний 2.3-р зүйлд заасанчлан Гэрээг хаах үйл ажиллагаа явагдах өдрийг ойлгоно;


“**Нууц мэдээлэл**” гэдэгт нийтийн зориулалттай веб хуудсан дээр тавигдсан мэдээллийг тооцохгүйгээр бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, процесс, төлөвлөгөө, ноу хау, дизайны эрх, худалдааны нууц, зах зээлийн боломжууд, үйлчлүүлэгчийн жагсаалт, худалдааны харилцаа холбоо, маркетингийн болон борлуулалтын материалтай холбоотой мэдээлэл, эсвэл Талуудын боловсруулсан буюу бусдаар бэлтгүүлсэн, Талуудын нууц буюу өмчлөлийн шинжтэй гэж үзсэн аливаа бусад мэдээллийг оролцуулаад (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) Талуудын бизнесийн үйл ажиллагаа, ажил хэрэг, үйлчлүүлэгчидтэй холбогдон хэрэглэгдэж буй бүх мэдээлэлийг ойлгоно;

“**Маргаан**” гэдэгт энэхүү Гэрээ эсвэл түүний аливаа заалтын хүчин төгөлдөр байдал, эсвэл энэхүү Гэрээ буюу түүний аливаа заалтын дагуу хүлээсэн үүрэгтэй холбогдон гарсан аливаа маргаан буюу саналын зөрөлдөөнийг оролцуулаад (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) энэхүү Гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг ойлгоно;

“**Хүчин төгөлдөр болох өдөр**” гэдэгт энэхүү Гэрээний удиртгал хэсэгт заасан өдрийг ойлгоно;

“**Давагдашгүй хүчин зүйл**” гэдэгт дайн ба иргэний дайн (зарлагдсан ба зарлагдаагүй), эсвэл дайсагнал (терроризм, хорлон сүйтгэх ажиллагаа, түйвээх, үймээн, бослого, хувьсгал болон бусад иргэний үймээн зэргийг оролцуулаад), дэлбэрэлт, бөмбөг дэлбэрэх, хөдөлмөрийн маргаан, ажил хаялт, локаут, ажил хаялт, үйл ажиллагаа хумигдах, карантинд орох, хөдөлмөрийн чадвараа алдах, гал түймэр, үер, шуурга, газар хөдлөх, хар салхи, ган, өвчин болон байгалийн бусад гамшиг буюу Монгол улсыг хамарсан сөрөг үзэгдлүүдийг оролцуулаад Талуудын хяналтаас гадуур болсон аливаа үйл явдал, хямрал, үйл явдлын чиг хандлага зэргийг ойлгоно;

“**Лиценз**” гэдэгт энэхүү Гэрээний Удиртгал хэсэгт заасныг ойлгоно;



“Хувьцаа” гэдэгт Компанийн гаргасан бөгөөд эргэлтэнд байгаа бүх энгийн хувьцааг ойлгоно;

“Татвар” гэдэгт холбогдох хуулийн дагуу энэхүү Гэрээтэй холбогдуулан Талуудад ногдуулсан аливаа төрлийн бүх татваруудыг ойлгоно;

“Төгрөг” гэдэгт Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг ойлгоно;

“ам.доллар” гэдэгт Америкийн нэгдсэн улсын долларыг ойлгоно.

2-Р ЗҮЙЛ ХУВЬЦААНЫ ЗАХИАЛГА; ХУВЬЦАА ХУДАЛДАХАД ЗЭРЭГ ОРОЛЦОХ ЭРХ

2.1. Захиалсан хувьцааны худалдан авах үнэ нь (68,850,000 төгрөгтэй тэнцэх) 51,000 (Тавин Нэгэн Мянган ам.доллар) (цаашид “Худалдан авах үнэ” гэх) ам.доллар байна.


2.2. Энэхүү Гэрээнд заасан нөхцөл, болзол, түүнчлэн энэхүү Гэрээнд агуулагдсан тохиролцоо, мэдэгдэл, баталгааг үндэслэн Компани нь НАТАЛЯ-1-д Захиалсан хувьцааг гаргаж, худалдах бөгөөд НАТАЛЯ-1 нь Компаниас аливаа барьцааны эрх, гуравдагч этгээдийн эрх болон аливаа төрлийн бусад эрхээс чөлөөтэйгээр оршдог Захиалсан хувьцааг худалдан авна.

2.3. НАТАЛЯ-1 нь энэхүү Гэрээний дагуу Захиалсан хувьцааг захиалж, төлбөрийг төлөхөд Компани нь:

- а) тийнхүү гаргасны дараа Компанийн эргэлтэнд байгаа нийт энгийн хувьцааны 51%-ийг төлөөлөх, бүрэн төлөгдсөн энгийн хувьцаа болох Захиалсан хувьцааг НАТАЛЯ-1д олгоно;
- б) Компанийн хувь нийлүүлэгчдийн бүртгэлд НАТАЛЯ-1-ийн нэрийг оруулна;
- в) Захиалсан хувьцааг зохих ёсоор зарласан, гаргасан болон хүргүүлсэн, түүнчлэн НАТАЛЯ-1-д тухайн хувьцааг олгоход хуульд заасан холбогдох бүх шаардлагыг зохих ёсоор биелүүлсэн тухай нотолгоог зохих ёсоор зарлан, гаргаж, хүргүүлснийг болон холбоотой хуулийн бүхий л шаардлагыг биелүүлсэн тухай нотолгоог НАТАЛЯ-1-ийн шаардсан хэмжээнд НАТАЛЯ-1-д гаргаж өгнө.

2.4

а) Хэрэв НАТАЛЯ-1 нь бодитоор худалдах хэлцэл (цаашид “Хувьцаа зэрэг худалдах худалдаа” гэх)-ээр өөрийн эзэмшлийн Хувьцааны нэг зуун хувь (100%)-ийг нэг буюу түүнээс дээш Этгээдэд худалдах буюу бусад хэлбэрээр шилжүүлэх саналтай байгаа бол НАТАЛЯ-1 нь Сумьяабазарыг оролцуулаад Хувь нийлүүлэгч тус бүр (цаашид “Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгч” гэх)-ийг өөрсдийн эзэмшлийн Хувьцааны нэг зуун хувь (100%)-ийг тухайн худалдан авах этгээдэд энэхүү Гэрээний 2.4(в) заалтад заасан үнээр болон Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь



нийлүүлэгчдийн эрх ашигт нийцсэн нөхцөлтэйгээр худалдах буюу бусад хэлбэрээр шилжүүлэхийг өөрийн үзэмжээр шаардаж болох бөгөөд ийнхүү тохиолдолд НАТАЛЯ-1 нь энэхүү 2.4 дэх заалтыг сахин биелүүлнэ.


б) НАТАЛЯ-1 нь тухайн Хувьцаа зэрэг худалдах худалдаа бий болохоор төлөвлөсөн өдрөөс гуч (30)-аас доошгүй хоногийн өмнө Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгчдэд тухайн Хувьцаа зэрэг худалдах худалдааны талаар бичиг (цаашид “Хувьцаа зэрэг худалдах мэдэгдэл” гэх)-ээр мэдэгдэнэ. Хувьцаа зэрэг худалдах мэдэгдэлд шилжүүлэн авах этгээдийн нэр, хаяг, шилжүүлэн авах этгээдийн төлөх төлбөрийн нийт дүн болон шилжүүлэн авах тухайн этгээдийн зөвшөөрсөн бусад нөхцөл, болзлуудыг заана.

в) Хувьцаа зэрэг худалдах худалдааны төлбөр болгож НАТАЛЯ-1 болон Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгч (цаашид хамтад нь “Худалдагч хувь нийлүүлэгч” гэх)-дэд төлсөн буюу төлөх нийт орлогыг Компани хөрөнгөө худалдаж, тийнхүү худалдсанаас олсон орлогыг Худалдагч хувь нийлүүлэгчдэд хуваарилахад баримтлах журмыг баримтлан хуваарилна.

г) Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгч тус бүр нь Хувьцаа зэрэг худалдах мэдэгдэлд заасан нөхцөл, болзлуудаар Хувьцаа зэрэг худалдах худалдаанд оролцоно. Харилцан хамааралгүй гуравдагч этгээдэд төлбөл зохих худалдан авах үнийн аливаа эскроу, төлбөрийн түр саатуулалт болон хэлцлийн зардал болон (Хувьцаагаа аливаа барьцааны эрх, гуравдагч этгээдийн эрхээс чөлөөтэйгээр эзэмшиж байх талаар эсвэл Хувь нийлүүлэгчийн Хувьцаа зэрэг худалдах худалдаанд оролцож, уг хэлцлийг дуусгах бүрэн эрхтэй холбоотойгоор гаргасан Хувь нийлүүлэгчийн мэдэгдэл, баталгаа болон нөхөн төлбөрөөс бусад нөхөн төлбөр бөгөөд энэ нөхөн төлбөрийг тухайн Хувь нийлүүлэгч төлнө) аливаа нөхөн төлбөрийг хэрэв тухайн Хувьцаа зэрэг худалдах худалдааны нийт үнийг тухайн худалдан авах үнийн эскроу, төлбөрийн түр саатуулалт, тохиролцоо, хэлцлийн зардал, нөхөн төлбөрийн нийт дүнгээр хассан бол Хувь нийлүүлэгч бүрийн хүлээн авах төлбөрийг хувь тэнцүүлэн багасгасан хэмжээгээр Хувь нийлүүлэгчид төлнө.

д) НАТАЛЯ-1 нь Хувьцаа зэрэг худалдах мэдэгдлийг хүргүүлснээс хойш ер (90) хоногийн дотор Хувьцаа зэрэг худалдах худалдааг Хувьцаа зэрэг худалдах мэдэгдэлд заасан нөхцөл, болзлоор дуусгана; харин, хэрэв тухайн Хувьцаа зэрэг худалдах худалдааг төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр хийх шаардлагатай бол уг зөвшөөрлийг авснаас хойш ажлын таван (5) өдрийн хугацаа өнгөрөх хүртэлх хугацаагаар шаардлагатай бол уг ер хоногийн хугацааг сунгана. Хэрэв Хувьцаа зэрэг худалдах худалдаа нь энэ хугацаанд дуусаагүй бол НАТАЛЯ-1 нь тийнхүү худалдааар төлөвлөсөн ажилтай холбогдуулан Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгчдийн үйлдэж, НАТАЛЯ-1-д хүргүүлсэн аливаа баримт бичгийг Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгч бүрд буцаан өгнө.

е) НАТАЛЯ-1 нь Хувьцаа зэрэг худалдах худалдаа дууссан талаар мэдэгдлийг Хувьцаа зэрэг худалдах худалдаа дууссаны дараа Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгчдэд мэдэгдэх бөгөөд Худалдагч хувь нийлүүлэгчдэд ногдох аливаа эскроу, төлбөрийн түр саатуулалт буюу худалдан авах үнийн зохицуулалт болон тэдгээрийн төлбөл зохих хэлцлийн зардлыг хасаад уг хэлцлийн дагуу Худалдагч хувь нийлүүлэгчдийн Хувьцааг шилжүүлсэн төлбөрт төлбөл зохих нийт төлбөрийг Худалдагч хувь нийлүүлэгчдэд шилжүүлэх бөгөөд тухайн хэлцэл дууссаныг болон



дууссан цагийг нотлох бусад баримт, тэдгээрийн нөхцлүүдийг аливаа Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгчийн шаардсанаар нэн даруй гаргаж өгнө. НАТАЛЯ-1 нь аливаа эскроу, төлбөрийн түр саатуулалт буюу аливаа зохицуулалтын төлбөрийг чөлөөлсөн даруйд бүх Худалдагч хувь нийлүүлэгчдэд тэдгээрийн шилжүүлсэн хувьцаатай холбогдуулан төлбөл зохих нэмэлт төлбөрийг даруйхан шилжүүлнэ.


ё) Энэхүү 2.4 дах заалтын аливаа хэсгийг үл хөндөн, ямарваа шалтгааны улмаас Хувьцаа зэрэг худалдах худалдааны дагуу Хувьцаа шилжээгүй байх тохиолдолд тухайн Хувьцаа зэрэг худалдах худалдааны талаар Хувьцаа зэрэг худалдах мэдэгдлийг НАТАЛЯ-1 хүргүүлсэн эсэхийг үл харгалзан НАТАЛЯ-1 нь аливаа Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгчийн өмнө хариуцлага хүлээхгүй.

ж) Хэрэв аливаа Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгч тухайн Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгчийн Хувьцааг шилжүүлэх хэлцлийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай аливаа баримт бичгийг хүргүүлээгүй бол НАТАЛЯ-1 нь тухайн Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгчид холбогдох худалдан авах үнийг хүргүүлж болох бөгөөд тийнхүү хүргүүлснээр тухайн Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгчийн Хувьцааг шилжүүлэх хэлцлийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай тухайн баримт бичгийг тухайн Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бүрэн эрхтэйгээр үйлдэж, хүргүүлнэ. Тухайн итгэмжлэл нь тухайн Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгч нас барах, эрх зүйн чадамжгүй болох, татан буугдах, дампуурахад хүчинтэй хэвээр байх бөгөөд тухайн Хувьцаа худалдахад зэрэг оролцох хувь нийлүүлэгчийн эрх залгамжлагч болон эрх шилжүүлэн авагчийн хамаарна.

3-Р ЗҮЙЛ ГЭРЭЭГ ХААХ УГТВАР НӨХЦЛҮҮД

3.1. Захиалсан хувьцааг худалдан авах үүргийг оролцуулаад энэхүү Гэрээгээр хүлээсэн НАТАЛЯ-1-ийн үүрэг нь дор дурдсан угтвар нөхцлүүд НАТАЛЯ-1-ийн шаардсан хэмжээнд биелэгдсэн нөхцөлд хэрэгжинэ. Үүнд:

- а) Компани нь энэхүү Гэрээний нөхцлүүдийн дагуу НАТАЛЯ-1-д Захиалсан хувьцаа зарлаж, гаргахыг зөвшөөрсөн энэхүү Гэрээний 2-р Хавсралтад заасан хэлбэрээр гаргасан Компанийн Хувь нийлүүлэгчийн тогтоолыг НАТАЛЯ-1-д хүргүүлсэн;
- б) Компани нь аудитын байгууллагаар баталгаажуулсан Компанийн хамгийн сүүлийн үеийн байдлаарх санхүүгийн тайланг НАТАЛЯ-1-д хүргүүлсэн;
- в) НАТАЛЯ-1 нь Лиценз дээр эрх зүйн хөндлөнгийн хяналтыг өөрийн шаардсан хэмжээнд хийлгүүлсэн бөгөөд НАТАЛЯ-1-ийн шаардсан хэмжээнд гаргасан Лицензийг шилжүүлэх бололцоо болон шилжүүлсний дараа тэдгээрийн хүчин төгөлдөр үйлчлэх байдлын талаарх эрх зүйн дүгнэлтийг Монгол дах хуулийн зөвлөхөөс хүлээн авсан бөгөөд НАТАЛЯ-1 нь тухайн шаардлагыг хангаж байгаа эсэхийг өөрийн үзэмжээр шийднэ.

A handwritten signature in black ink is located in the bottom right corner of the page. The signature is stylized and appears to be written over a circular stamp or seal, though the details of the stamp are not clearly visible. The signature is written in a cursive style.

- г) Компани нь өөрийн Дүрэм, Компанийн тал болж орсон буюу үүрэг хүлээсэн (энэхүү Гэрээг оролцуулаад) аливаа баримт бичиг, эсвэл холбогдох аливаа хууль тогтоомж, дүрэм, журмын заалтыг зөрчөөгүй байна;
- д) Компанийн бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө, хөрөнгөжилт, санхүүгийн нөхцөл байдал эсхүл энэхүү Гэрээ болон Хувь нийлүүлэгчийн гэрээнд заасан хэлцлийг хэрэгжүүлэх эрх зүйн чадварт нь сөрөг нөлөө үзүүлж болохуйц ямарваа нөхцөл байдал үүсээгүй.
- е) Компанийн энэхүү Гэрээгээр баталсан мэдэгдэл, баталгаа нь үнэн зөв хэвээр байна.

3.2. Энэхүү Гэрээний 3-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан угтвар нөхцлүүд нь НАТАЛЯ-1-ийн эрх ашгийг хамгаалах зорилготой. Энэхүү Гэрээнд гарын үсэг зурснаас хойш Компани нь түүнд заасан угтвар нөхцлүүдийг биелүүлэхэд шаардлагатай бүх үйлдлийг хийх болон шаардлагатай бүх мэдээлэл, баримт бичгээр хангахад хүчин чармайлт гаргана.

3.3. НАТАЛЯ-1 нь энэхүү Гэрээний 3.1 дэх заалтад заасан нэг буюу түүнээс дээш угтвар нөхцлүүдээс Гэрээг хаахаас өмнө өөрийн үзэмжээр татгалзаж болно.

3.4. Энэхүү Гэрээний 3.3 дах заалт болон бусад заалтуудыг үл хөндөн, энэхүү Гэрээний 3.1 дэх заалтад заасан угтвар нөхцлүүд 2010 оны 8-р сарын 31-ний өдрийн дотор биелэгдээгүй байвал НАТАЛЯ-1 нь энэхүү Гэрээ болон энэхүү Гэрээгээр хүлээсэн бүх үүргээ цуцалж болох бөгөөд харин тийнхүү цуцлах үүрэггүй.


4-Р ЗҮЙЛ МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА

4.1. Компани болон Сумьяабазар нь дор дурдсан мэдэгдэл болон баталгааг хамтдаа буюу тус тусдаа үүгээр гаргаж байгаа бөгөөд НАТАЛЯ-1 нь эдгээр мэдэгдэл, баталгаанд итгэж болохыг Компани болон Сумьяабазар үүгээр баталж байна. Үүнд:

4.1.1. Компани нь Монгол улсын хуулийн дагуу зохих ёсоор байгуулагдан, үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа хязгаарлагдмал хариуцлагатай компани мөн болно. Компани нь хуулийн этгээдийн эрхтэй бөгөөд өөрийнхөө эд хөрөнгийг эзэмших, одоо явуулж байгаа үйл ажиллагаагаа явуулах болон энэхүү Гэрээг байгуулж, хүлээсэн үүргээ биелүүлэх эрхтэй.


4.1.2. Компанийн зарласан хөрөнгө нь нэг бүр нь 10,000 (арван мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 (нэг зуу) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. Энэхүү Гэрээг байгуулах өдрийн байдлаар Компанийн зарласан бүх Хувьцааг гаргасан бөгөөд тэдгээр нь эргэлтэнд байгаа.

4.1.3. Энэхүү Гэрээний дагуу НАТАЛЯ-1-д олгох Захиалсан хувьцаанаас өөр Компанийг хувьцаа гаргах, Компанийг аливаа хувьцаа худалдах буюу



шилжүүлэхэд хүргэх аливаа гаргасан буюу зарласан опцион, худалдан авах эрх, хувьцаа захиалах эрх, хөрвүүлэх эрх, солилцох эрх болон бусад гэрээ буюу үүрэг байхгүй.

- 4.1.4. Компани нь төрийн байгууллагын зөвшөөрөл болон татгалзалыг оролцуулаад (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) энэхүү Гэрээг байгуулах болон Гэрээнд заасан хэлцлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан болно. Энэхүү Гэрээ нь Компанийн хувьд Гэрээний нөхцөл, болзлуудын дагуу хэрэгжих хүчин төгөлдөр, заавал биелэгдэх хууль зүйн хүчинтэй үүрэг нь байна.
- 4.1.5. Компаниас энэхүү Гэрээг үйлдэх, хүргүүлэх, түүнд тусгасан хэлцлийг хэрэгжүүлэх нь ямарваа хууль, дүрэм журам, тушаал болон засгийн газрын аливаа агентлаг, эсвэл шүүхээс тогтоосон ямарваа нэг хязгаарлалтыг зөрчихгүй.
- 4.1.6. Компани нь боломжит хөрөнгө оруулагчийн шийдвэр буюу ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхүйц аливаа гэрээнд тал болон ороогүй буюу орох үүрэг хүлээгээгүй.
- 4.1.7. Компани нь засгийн газрын аливаа эрх бүхий байгууллагын аливаа дүрэм журмыг зөрчөөгүй бөгөөд Компанийн мэдэж байгаагаар ямарваа шүүх ажиллагаа болон хянан шийдвэрлэх ажиллагаа Компанийн эсрэг явагдаагүй, явуулахыг завдаагүй.
- 4.1.9. (i) Компанийн эсрэг, эсвэл түүний бизнесийн үйл ажиллагаа болон түүний эзэмшиж, ашиглаж буй аливаа эд хөрөнгөтэй холбоотой буюу түүнд сөргөөр нөлөөлөхүйц, эсхүл (ii) Компаниас НАТАЛЯ-1-д Захиалсан хувьцаа шилжүүлэхэд саад болохуйц хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаагүй байгаа. Тийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахыг завдаагүй бөгөөд тийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах үйл явдал, нөхцөл байдал үүсээгүй болно;
- 4.1.10. Компанийг Сумьяабазарт хувьцааныхаа аливаа хэсгийг гаргах, худалдах эсхүл өөр бусад байдлаар эргэлтэнд оруулахад хүргэх аливаа биелэгдээгүй эсхүл эрх олгосон опцион, баталгаа, худалдан авах эрх, захиалгын эрх, хөрвүүлэх эрх, солилцооны эрх болон бусад гэрээ буюу үүрэг байхгүй. Хувьцаатай холбоотой Сумьяабазарын санал өгөх эрх, эсвэл Сумьяабазарын эзэмшиж байгаа Компанийн хувьцаатай холбоотой аливаа санал өгөх итгэмжлэл, гэрээ буюу тохиролцоо байхгүй;
- 4.1.12. Компани нь энэхүү Гэрээг байгуулахаас өмнө НАТАЛЯ-1-д урьдчилан бичгээр танилцуулснаас өөр бусад их хэмжээний буюу тохиолдлын өр төлбөр болон үүрэг хариуцлага байхгүй;
- 4.1.13. НАТАЛЯ-1-д танилцуулаагүй, тал болон орсон аливаа гэрээ (буюу хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн гэрээ) байхгүй. Компани нь нөхөрлөл, эсвэл хамтарсан компани байгуулахтай холбоотой аливаа гэрээ байгуулаагүй. Компанийн нэрийн өмнөөс үйлдэж, олгосон аливаа



итгэмжлэл байхгүй. Компани нь аливаа бусад этгээд, охин компани болон хуулийн этгээдийн үүрэг хариуцлага (өр төлбөрийг оролцуулаад)-д баталгаа гаргаагүй бөгөөд өөр бусад байдлаар тэдгээр төлбөр буюу үүргийг хариуцаагүй;

4.2. Энэхүү Гэрээний 4.1 дэх хэсэгт дурдсан Компанийн мэдэгдэл болон баталгаа нь бодит байдлыг төөрөгдүүлэхүйц мэдээлэл агуулаагүй бөгөөд энэхүү Гэрээнд заасан мэдээллийн үнэн бодит байдлыг алдагдуулахгүй байх үүднээс ямарваа бодит мэдээллийг орхигдуулаагүй болно. Компанийн гаргасан бүх мэдэгдэл, баталгаа нь энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар Гэрээг хаах өдөр үнэн зөв хэвээр байх бөгөөд энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш тав (5)-ан жилийн хугацаанд хүчинтэй хэвээр байна. Дээрх мэдэгдэл болон баталгааны аль нэг нь үнэн зөв бус байсан нь тогтоогдож, уг зөрчлийг арилгахтай холбоотойгоор НАТАЛЯ-1 болон түүний эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн эсвэл хувь нийлүүлэгч (цаашид “**Нөхөн төлбөр хүлээн авагч**” гэх)-дэд учирч болох (өмгөөлөгчийн хөлсийг оролцуулаад) аливаа зардал, өртөг, алдагдлаас Компани нь Нөхөн төлбөр хүлээн авагчийг үүгээр чөлөөлж байна.

4.3. Талууд нь энэхүү Гэрээг үйлдсэн өдрөөс Гэрээг хаах хүртэлх хугацаанд дор дурдсан үйлдлүүдийг хийхээ үүгээр хүлээн зөвшөөрч байна. Үүнд:

- 4.3.1. Компани нь өөрийн бизнесийн ердийн үйл ажиллагаанаас гадуур аливаа үйл ажиллагаа явуулахгүй, үйлдэл хийхгүй буюу гэрээ байгуулахгүй;
- 4.3.2. Компани нь Компанийн санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж болохуйц ямар нэг гэрээ болон үйлдэл хийхгүй;
- 4.3.3. Сумьяабазар нь Компанид хамаарах бүх байшин барилга, өмч хөрөнгө, ажиллагсад, санхүүгийн баримт бичиг, тайлан (татварын тайланг оролцуулаад), гэрээ болон бусад бичиг баримттай танилцах зөвшөөрлийг Худалдан авагчийн төлөөлөгчдөд олгох буюу тийм боломжоор хангана;
- 4.3.4. Сумьяабазар ба/буюу Компани нь Компанид холбоотой буюу энэхүү Гэрээнд дурдсан өөрийн гаргасан аливаа мэдэгдэл болон баталгааг зөрчихөд хүргэхүйц ноцтой сөрөг нөлөө бүхий үйл ажиллагааны талаар Худалдан авагчид бичгээр нэн даруй мэдэгдэнэ;
- 4.3.5. Сумьяабазар нь (i) аливаа этгээдийг Компанийн гаргасан аливаа хувьцааг худалдаж авахыг, эсвэл тийнхүү худалдаж авах санал тавихыг ятгахгүй буюу дэмжихгүй, буюу (ii) аливаа этгээдийн Компанийн гаргасан аливаа хувьцааг олж авах тухай яриа, хэлэлцээнд оролцохгүй, түүнтэй холбогдуулан аливаа мэдээллээр хангахгүй, түүнчлэн ямар нэг байдлаар тусалж, дэмжихгүй. Сумьяабазар нь өмнө дурдсантай холбогдуулан хэн нэгэн этгээдээс аливаа санал, хүсэлт хүлээн авсан буюу тухайн этгээд уг асуудлаар холбоо тогтоохыг оролдсон тохиолдолд энэ тухай НАТАЛЯ-1-д нэн даруй мэдэгдэнэ.

5-Р ЗҮЙЛ ТАЛУУДЫН ҮҮРЭГ

5.1. Талууд нь энэхүү Гэрээнд заасан хэлцлийг дуусгах болон хүчин төгөлдөр болгоход шаардлагатай буюу зохих бүхий л үйлдлийг хийнэ.

6-Р ЗҮЙЛ ЗӨРЧИЛ БА ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

6.1. Компани болон Сумьяабазарын энэхүү Гэрээний зорилгоор гаргасан аливаа мэдэгдэл болон баталгаа энэхүү Гэрээнд гарын үсэг зурснаас хойш тав (5)-ан жилийн хугацаанд хэдийд ч үнэн зөв бус гэдэг нь тогтоогдох зэргийг оролцуулаад Талуудын аль нэг нь энэхүү Гэрээгээр хүлээсэн аливаа үүргээ биелүүлээгүй бол нөгөө тал нь бичгээр мэдэгдэл хүргүүлж, уг зөрчлөө арилгахыг зөрчил гаргагч талаас шаардах эрхтэй. Зөрчил гаргагч тал нь уг мэдэгдлийг хүлээн авнаас хойш ажлын долоо (7)-н өдрийн дотор гаргасан зөрчлөө арилгах бөгөөд хэрэв уг зөрчил нь ажлын долоо (7)-н өдрийн дотор засагдах боломжгүй бол тэрхүү зөрчлийг арилгах ажлыг яаралтай эхлүүлж, дуусгана.

6.2. Хэрэв зөрчил гаргагч тал нь өмнөх хэсэгт заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй буюу арилгахаар ажиллаагүй бол нөгөө тал нь зөрчил гаргагч талд бичгээр мэдэгдэж, энэхүү Гэрээг цуцлах эрхтэй бөгөөд зөрчил гаргагч тал уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөр энэхүү Гэрээ дуусгавар болно. Гэрээг тийнхүү цуцалсан тохиолдолд Компани нь НАТАЛЯ-1-ийн Компани (буюу Худалдагчийн томилсон төлбөр хүлээн авах эрх бүхий этгээд)-ид төлсөн Худалдан авах үнийн бүх төлбөрийг ажлын арав (10) хоногийн дотор эргүүлэн төлнө. НАТАЛЯ-1 нь Компанид төлсөн бүх мөнгөө хүлээн авсан даруй Захиалсан хувьцааг Компанид шилжүүлнэ. Энэхүү Гэрээг цуцлах нь холбогдох хуулийн дагуу талуудын хохирол нэхэмжлэх аливаа эрх буюу хохирлоо арилгуулах эрхийг хөндөхгүй.


7-Р ЗҮЙЛ НУУЦЛАЛ

7.1. Талууд нь энэхүү Гэрээний нөхцлүүд болон энэхүү Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан танилцуулсан нууц мэдээллийн нууцыг чандлан хадгална. Аливаа тал нь нөгөө талын бичгээр урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд аливаа мэдээллийг задруулах, хэвлэлд нийтлүүлэх буюу нийтэд задруулахгүй.

8-Р ЗҮЙЛ ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ БА АРБИТР

8.1. Энэхүү Гэрээг хуулиудын зөрчилдөөний хэм хэмжээг үл харгалзан Монгол улсын хуулиар тайлбарлаж, зохицуулна.

8.2. Энэхүү Гэрээний хүчин төгөлдөр байдалтай холбоотой маргааныг оролцуулаад энэхүү Гэрээтэй холбогдон гарах аливаа маргааныг Монгол улсын Худалдаа аж үйлдвэрийн танхимын Арбитрийн шүүхээр эцэслэн шийдвэрлүүлэхээ Талууд эргэлт буцалтгүй зөвшөөрч байна. Арбитрын шүүхийн аливаа шийдвэр нь эцсийн бөгөөд заавал биелүүлэх хуулийн хүчинтэй байх бөгөөд Талууд нь тодруулга хүсэх болон



хууль ба/буюу шүүхийн шийдвэрийг давж заалдах аливаа эрхээсээ үүгээр татгалзаж байна. Энэхүү Гэрээний аливаа Талд гаргасан Арбитрын бүх шийдвэрийн төлбөрийг ам.доллараар төлнө.

8.3. Маргаанд ялагч талд өмгөөлөгчийн хөлс болон бусад зардлыг оролцуулаад, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй, бүх зардлыг нөхөн төлнө.

9-Р ЗҮЙЛ БУСАД ЗҮЙЛ

9.1. Энэхүү Гэрээний дагуу энэхүү Гэрээний аль нэг Талаас нөгөө Талдаа хүргүүлэх аливаа болон бүх мэдэгдэл болон бусад баримт бичгийг бичгээр үйлдэж, биечлэн буюу факсаар, эсвэл Талуудын харилцан тохиролцсон бусад аргаар дараах этгээд буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчид хүргүүлнэ. Үүнд:

Компанид:

Нэр	Новаметал Ресурс ХХК
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Үндэсний циркийн төв байр, 3-р давхар
Хот	Улаанбаатар-16030
Улс	Монгол
Утас	976-11-686982
Факс	976-11-689911


Сумъяабазарт:

Нэр	Долгосүрэнгийн Сумъяабазар
Хаяг	Сөүлийн гудамж 6А, Сити Плаза, Монголын Үндэсний хөрөнгө оруулалтын банк, 2-3-р давхар
Хот	Улаанбаатар
Улс	Монгол
Утас	976-321995
Факс	976-390913

НАТАЛЯ-1-д:

Нэр	NATALYA-1
Хаяг	74, rue de Merl, 1 st
Хот	L-2146
Улс	Luxembourg
Утас	+1 212 698 9260
Факс	+1 212 698 9266

Бүх мэдэгдлийг хүлээн авагч тэдгээрийг хүлээн авсан өдөр хүргүүлсэнд тооцно.



10

9.2. Аливаа тал нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас энэхүү Гэрээгээр хүлээсэн үүрэг (төлбөрийн үүргээс бусад)-ээ биелүүлээгүй буюу үүргийн гүйцэтгэлээ хойшлуулсан бол нөгөө талынхаа өмнө хариуцлага хүлээхгүй бөгөөд уг давагдашгүй хүчин зүйлүүдийн улмаас хойшилсон үүргийн гүйцэтгэлийг биелүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээг авна. Хэрэв аль нэг Тал нь Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалж энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэх боломжгүй бол уг Талын үүрэг хариуцлагын хэмжээг бололцооны хэмжээнд хүртэл хөнгөлж өгөх бөгөөд тийнхүү чөлөөлөх нь уг Талд нөгөө талынх нь өмнө ямарваа үүрэг хариуцлага хүлээлгэхгүй.

9.3. Энэхүү Гэрээ болон түүнд заасан мэдэгдэл, баталгаа болон нөхцлүүд нь Талууд, тэдгээрийн эрх залгамжлагч, төлөөлөгч, эрх шилжүүлэн авагчдын хувьд заавал биелэгдэх хуулийн хүчинтэй байна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү Гэрээний мэдэгдэл болон баталгаа нь Захиалсан хувьцааг НАТАЛЯ-1-д шилжүүлж дуусах хүртэл хүчинтэй байна.

9.4. Энэхүү Гэрээнд гагцхүү Талууд болон Талуудын өмнөөс зохих ёсоор бичгээр үйлдсэн баримтаар нэмэлт өөрчлөлт оруулна.

9.5. Энэхүү Гэрээ нь Талуудын хооронд өмнө нь аман ба бичгээр байгуулсан бүх гэрээ хэлцэл, мэдэгдэл, баталгааг хүчингүй болгож байгаа бөгөөд зөвхөн Гэрээнд заасан хэлцлүүдтэй холбоотой асуудлаарх Талуудын тохиролцоог бүхэлд нь агуулж байгаа болно.

9.6. Цаг хугацааны асуудал бол энэхүү Гэрээний чухал зүйл мөн.


9.7. Энэхүү Гэрээний аливаа заалт нь хүчингүй, хууль бус болох нь тогтоогдсон ч энэхүү Гэрээний үндсэн нөхцөл, болзлууд нь хүчинтэй хэвээр байвал бусад заалтууд нь хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Талууд нь энэхүү Гэрээний аливаа заалтыг хүчингүй, хууль бус гэж үзсэн тухайн хуулийн аливаа заалтаас Монгол улсын хуулиар зөвшөөрсөн хэмжээгээр татгалзана.

9.8. Энэхүү Гэрээ нь Талуудын эрх ашгийн төлөө үйлчлэх бөгөөд энэхүү Гэрээний аливаа заалт нь Талууд, тэдгээрийн эрх залгамжлагч болон эрх шилжүүлэн авагчдаас өөр бусад этгээдэд аливаа эрх буюу зөрчил арилгуулах эрхийг олгохгүй.

9.9. Энэхүү Гэрээг Англи ба Монгол хэлээр үйлдсэн бөгөөд Гэрээний үг хэллэгийг тайлбарлахтай холбогдон маргаан гарсан тохиолдолд англи хувь нь шийдвэрлэгч байна.

9.10. Энэхүү Гэрээг нэг буюу түүнээс олон хувь үйлдэж болох бөгөөд хамтдаа нэг баримт бичгийг бүрдүүлнэ. Энэхүү Гэрээ нь Талууд нэг буюу түүнээс олон хувь дээр гарын үсэг зурж, нөгөө Талдаа хүргүүлсэн өдөр хүчин төгөлдөр болох бөгөөд Талууд бүх хувиуд дээр гарын үсэг шаардлагагүй гэж ойлгоно.


(зориуд хоосон үлдээв)

Handwritten signature in black ink, consisting of several loops and strokes, positioned above the page number 11.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТЛОН, Талууд нь энэхүү Гэрээг түүний эхэнд бичигдсэн он, сар, өдөр байгуулав.


Новаметал Ресурс ХХК-ийг төлөөлж

Гарын үсэг:



Д.Сумьяабазар
Үүсгэн байгуулагч

Гарын үсэг:



Д.Сумьяабазар

НАТАЛЯ-1 С.А.Р.Л.-ийг төлөөлж:

Гарын үсэг:


Жэймс Пассин
Захирал

Гарын үсэг:

Харви Соикин
Захирал

Гарын үсэг:

Энтони Милевски
Захирал



12